

Захирлын 2015 оны 01 дугаар сарын 15  
өдрийн 15 дугаар тушаалын хавсралт

**2014-2015 оны хичээлийн жилд элссэн Бакалаврын түвшний оюутны  
мэргэжлийн хөтөлбөр сонгох журам**

**Нэг. Журмын зорилго, үйлчлэх хүрээ**

1.1. Энэхүү журмын зорилго нь МУИС-д элсэн суралцаж, ерөнхий суурь хичээл судалсан оюутнуудад бакалаврын зэрэг олгох мэргэжлийн хөтөлбөр сонгуулах үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой аливаа асуудлыг зохицуулахад оршино.

1.2. Шинжлэх ухааны сургууль (цаашид ШУС гэнэ), Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль (цаашид ХШУИС гэнэ), Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль (цаашид ОУХНУС гэнэ)-д 2014-2015 оны хичээлийн жилд элсэж, МУИС-ийн Ерөнхий суурийн 24-өөс доошгүй багц цагийн хичээл (Үүнд байгалийн ухаан, нийгмийн ухаан, хүмүүнлэгийн ухаан, англи хэл, бусад хэлний хичээлээс тус бүр 3-аас доошгүй багц цаг орно)-ийг амжилттай судалсан оюутан цаашид суралцах мэргэжлийн хөтөлбөрөө 2014-2015 оны хичээлийн жилийн хаврын улирлын эцэст сонгоно.

1.3. Бизнесийн сургууль (цаашид БС гэнэ) болон Орхон сургууль (цаашид ОС гэнэ), Завхан сургууль (цаашид ЗС гэнэ)-д 2014-2015 оны хичээлийн жилд элсэж ерөнхий суурь болон мэргэжлийн суурийн 36-аас доошгүй багц цагийн хичээлийг амжилттай судалсан оюутан мэргэжлийн хөтөлбөрөө 2015-2016 оны хичээлийн жилийн намрын улирлын эцэст сонгоно. Эдгээр сургуулиудын мэргэжлийн хөтөлбөр сонголтын зохион байгуулах хугацааг тусад нь зарлана.


1.4. Хууль зүйн сургууль нэг хөтөлбөртэй тул энэ журам үйлчлэхгүй. Түүнчлэн гадаад оюутны мэргэжлийн хөтөлбөр сонголт нь энэхүү журмаас гадна хоёр улсын гэрээ болон бусад эрх зүйн баримт бичгээр зохицуулагдана.

1.5. 2013-2014 оны багц хөтөлбөрөөр элссэн оюутнуудын мэргэжил сонголтыг бүрэлдэхүүн сургуулиудын сургалтын албад тусад нь зохион байгуулна.

1.6. 2013-2014 оны хичээлийн жил болон үүнээс өмнө тодорхой мэргэжлээр элссэн, чөлөөнөөс ирж суралцаж байгаа оюутнууд анх элссэн мэргэжлээрээ цаашид суралцах хүсэлтэй бол онооны жагсаалтад оролгүйгээр 2014-2015 оны хичээлийн жилээс хэрэгжиж байгаа сургалтын шинэ хөтөлбөрөөр үргэлжлүүлэн суралцана. Оюутан элссэн мэргэжлээрээ үргэлжлүүлэн суралцахгүй бол энэхүү журмын дагуу өөр мэргэжлийн хөтөлбөр сонгох боломжтой.

1.7. 2014-2015 оны хичээлийн жилд элссэн оюутнууд мэргэжлийн хөтөлбөрөө ШУС-ийн Байгалийн ухааны салбар (цаашид БУС гэнэ), Нийгмийн ухааны салбар (цаашид НУС гэнэ), Хүмүүнлэгийн ухааны салбар (цаашид ХУС гэнэ) тус бүрээр, ХШУИС, Бизнесийн сургууль, ОУХНУС

суралцаж буй бүрэлдэхүүн сургууль/салбарт хэрэгжиж байгаа хөтөлбөрүүдийн хүрээнд батлагдсан хяналтын тоонд багтаан сонгоно.



1.8. Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн дэд хорооноос ирүүлсэн мэргэжлийн хөтөлбөр бүрээр суралцах оюутны хяналтын тооны саналыг МУИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хорооны хурлаар хэлэлцэж, шийдвэрийг МУИС-ийн Захирлын тушаалаар баталгаажуулна. Бүрэлдэхүүн/салбар сургуулиас ирүүлсэн хяналтын тоо 2014 онд Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан МУИС-ийн бүрэлдэхүүн/салбар сургуулиудад бакалаврын хөтөлбөрт суралцуулах оюутны хяналтын тооноос илүү гарахгүй байна.

1.9. Оюутны цаашид үргэлжлүүлэн суралцах мэргэжлийн хөтөлбөрийн жагсаалт, оюутны хяналтын тоог 2015 оны 1 дүгээр сард багтаан МУИС-ийн цахим хуудсаар нийтэд мэдээлнэ.

1.10. Мэргэжлийн хөтөлбөр сонголтыг ОУХНУС, ХШУИС, ШУС-д 2015 оны 6 дугаар сарын 15-наас хойш ажлын 5 хоногт багтаан энэ журмын 3-р бүлэгт заасны дагуу явуулна.

1.11. Мэргэжлийн хөтөлбөр сонголтын баталгаажуулалтын дүнг бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн дэд хороогоор хэлэлцэн цаашид хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийн талаар шийдвэр гаргана.

1.12. Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн дэд хорооны шийдвэрт үндэслэн бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба мэргэжлийн хөтөлбөр сонгосон оюутны нэрс, бүртгэлийн дугаар, регистрийн дугаар, жагсаалтын оноо зэрэг бусад шаардлагатай мэдээллийг хөтөлбөр тус бүрээр нэгтгэн гаргаж Сургалтын нэгдсэн алба хянаж МУИС-ийн Захирлын тушаалаар баталгаажуулна.

1.13. Оюутан мэргэжлийн хөтөлбөр сонголтоос хоцорсон тохиолдолд шалтгаанаас үл хамааран дараагийн улиралд үлдсэн хуваариас сонгоно.

1.14. Мэргэжлийн хөтөлбөр сонгох сонголтоо оюутан өөрийн хүсэлтээр нэг удаа хойшлуулж болно. Хүсэлтийг мэргэжлийн хөтөлбөрт санал өгөх хугацаа дуусахаас өмнө бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанд бичгээр (хавсралт 2) гаргана. Хүсэлт гаргасан улирлаас үл хамааран тухайн оюутан дараагийн хичээлийн жилд элссэн оюутнуудтай хамт мэргэжлээ сонгоно. Энэ тохиолдолд оюутан Ерөнхий суурь хичээлийн болон чөлөөт сонголтын багц цагийг цуглуулж болно.

#### **Хоёр. Мэргэжил сонгуулах комисс**

2.1. МУИС-ийн Захирлын тушаалаар байгуулагдсан мэргэжлийн хөтөлбөр сонгуулах төв болон салбар комисс (цаашид төв, салбар комисс гэнэ ) мэргэжлийн хөтөлбөр сонгуулах ажлыг зохион байгуулна.

2.2. Төв комисс нь МУИС-ийн сургалт эрхэлсэн дэд захирал, Сургалтын нэгдсэн албаны дарга, Мэдээллийн технологийн албаны дарга болон бүрэлдэхүүн сургуулиудын хөтөлбөрийн дэд хорооны ахлагч, сургалтын нэгдсэн албаны хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн нараас бүрдэнэ. Комиссын дарга нь МУИС-ийн сургалт эрхэлсэн дэд захирал, нарийн бичгийн дарга нь СНА-ны хөтөлбөр хариуцсан



мэргэжилтэн байна.

2.3. Төв комисс энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж, салбар комиссын хүүрэнд энэ журмаар шийдвэрлэх боломжгүй асуудалд хариу өгнө.

2.4. Салбар комисс нь бүрэлдэхүүн сургуулийн захирал, дэд захирал, сургалтын албаны эрхлэгч, тэнхим/нэгжийн эрхлэгч, сургалтын албаны хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн нараас бүрдэнэ. Дарга нь бүрэлдэхүүн сургуулийн захирал, нарийн бичгийн дарга нь сургалтын албаны эрхлэгч байна.

2.5. Салбар комисс мэргэжил сонгох үйл ажиллагааг зохион байгуулж, холбогдох санал хүсэлтийг шийдвэрлэнэ.

2.6. Эцэг, эхийн төлөөлөл салбар комиссын албан ёсны зөвшөөрөлтэйгөөр хөндлөнгийн ажиглагчаар оролцож болно. Хөндлөнгийн ажиглагчаар оролцох хүсэлтээ мэргэжлийн хөтөлбөрийн сонголт эхлэхээс долоо хоногийн өмнө салбар комисст бичгээр ирүүлсэн байна.

### **Гурав. Мэргэжлийн хөтөлбөр сонгуулах үйл ажиллагаа**

3.1. Мэргэжлийн хөтөлбөр сонгуулах үйл ажиллагаа нь нэгдүгээрт, хөтөлбөр бүрээр суралцах оюутны хяналтын тоог тогтоох, хоёрдугаарт, тогтоосон хяналтын тоонд багтаан мэргэжил сонгуулах гэсэн хоёр үе шаттай байна.

3.1.1. Хөтөлбөр бүрээр суралцуулах оюутны хяналтын тоог дараах дарааллаар тогтооно:

а. Оюутан нэг хичээлийн жилд мэргэжил сонгох тандалтын судалгаанд хоёроос доошгүй удаа оролцож цаашид суралцахаар зорьж буй гурван (ОУХНУС-ийн хувьд хоёр) мэргэжлийн саналыг СИСИ мэдээллийн системээр өгнө.


б. Эхний тандалтыг оюутан МУИС-д элсэх эрхээ баталгаажуулах бүртгэлийн үед өгнө. Хоёр дахь тандалтыг 2014 оны 12 дугаар сард (БС, Орхон, Завханы сургуулийн хувьд 1-р тандалтыг 2015 оны 1 дүгээр сард, хоёр дахь тандалтыг 2015 оны 6 дугаар сард) багтаан явуулна.

в. Сургалтын нэгдсэн алба мэргэжил сонгох тандалтын үр дүнг тандалт явагдаж дууссанаас хойш 3 хоногийн дотор нэгтгэн МУИС-ийн захиргаа болон бүрэлдэхүүн сургуулиудад мэдээлнэ.

г. Тэнхим/нэгжийн хөтөлбөрийн дэд хороо нь мэргэжлийн хөтөлбөрт суралцах оюутны хяналтын тоо тогтоох аргачлал (хавсралт 1)-ын дагуу тухайн мэргэжлээр суралцуулах оюутны хяналтын тооны саналаа 2015 оны 1 дүгээр сард (БС, Орхон, Завханы сургуулийн хувьд 2015 оны 9 дүгээр сард) багтаан бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн дэд хороонд хүргүүлнэ.

д. Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн дэд хороо тэнхим/нэгжийн саналыг хянаж бүрэлдэхүүн сургуулийн мэргэжлийн хөтөлбөрүүдийн хяналтын тооны талаарх саналыг нэгтгэн 2015 оны 2 дугаар сарын 10-ны дотор МУИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хороонд хүргүүлнэ.

3.1.2. Мэргэжил сонгуулах үйл ажиллагааг дараах дарааллаар зохион байгуулна:



а. Бүрэлдэхүүн сургуулийн тэнхим/нэгж, сургалтын албанаас оюутанд мэргэжил сонгохтой холбоотой мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулна.

б. Бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба оюутны сурлагын голч дүн, амжилттай судалсан хичээлийн багц цаг, МУИС-д элсэхэд тооцуулсан элсэлтийн ерөнхий шалгалтын оноог 68:27:5 харьцаагаар тооцож дараах томъёог ашиглан онооны жагсаалтыг гаргана.

$$\text{Оюутны оноо} = \frac{\text{Голч}}{4.0} \times 68 + \frac{\text{Цуглуулсан багц цаг}}{42} \times 27 + \frac{\text{ЭШОноо}}{800} \times 5$$

Сурлагын голч дүн бодоход сургалтын журамд заасан CR-аас бусад үсгэн тэмдэглэгээг тооцохгүй.

в. Мэргэжлийн хөтөлбөр сонголт нь саналаа өгөх, саналаа баталгаажуулах гэсэн 2 үе шаттай явагдана.

г. 2015 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 9.00 цагт оюутны онооны жагсаалт СИСИ системд гарна. Оюутан онооны жагсаалт гарсны дараа 2015 оны 6 дугаар сарын 15-ны 9.00 цагаас 6 дугаар сарын 16-ны 17.00 цаг хүртэл цаашид суралцах мэргэжлийн хөтөлбөрүүдэд саналаа өгнө.

д. Бүрэлдэхүүн сургуулиас хамааран оюутны өгөх саналын тоо ялгаатай байна. ШУС (салбар тус бүрээр), ХШУИС, БС, Орхон, Завхан сургуулийн оюутнууд 4, ОУХНУС 1 мэргэжлийн хөтөлбөрт санал өгөх боломжтой.

е. Саналаа баталгаажуулах шат 3 өдөр үргэлжлэх бөгөөд 2015 оны 6 дугаар сарын 17-ны 9.00 цагаас 20.00 цаг хүртэл тухайн хөтөлбөрийн хяналтын тоонд багтсан оюутан СИСИ мэдээллийн системд өөрийн эрхээр орж зөвхөн нэг мэргэжлээр сонголтоо баталгаажуулна.

ё. Оюутан мэргэжлийн хөтөлбөр сонголтоо баталгаажуулахад бусад хөтөлбөрт түүний өгсөн санал хүчингүй болно. Энэ хугацаанд жагсаалтын дагуу хяналтын тоонд нэмж багтсан оюутнууд сонголтоо баталгаажуулах боломжтой.

ж. 2015 оны 6 дугаар сарын 18-ны 9.00 цагаас 20.00 цаг хүртэл хяналтын тоонд нэмж багтсан оюутнуудын мэргэжил сонголт үргэлжлэн явагдана.

з. 2015 оны 6-р сарын 18-ны 20.00 цаг гэхэд мэргэжлийн хөтөлбөрөө системээр сонгож чадаагүй оюутан үлдсэн тохиолдолд бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба 6 дугаар сарын 19-ний 10.00 цагаас онооны жагсаалтын дагуу үлдсэн мэргэжлийн хөтөлбөрөөс сонгуулах үйл ажиллагааг сургалтын албанаас зохион байгуулна. Энэ үед оюутан сургалтын албанаас зарласан өдөр, цагт биеэр хүрэлцэн ирэх шаардлагатай.

и. МУИС-ийн Захирлын тушаалаар баталгаажсанаар оюутан цаашид суралцах хөтөлбөрийн хичээлүүдийг СИСИ мэдээллийн системээр сонгож судлах эрхтэй болно.



Мэргэжлийн хөтөлбөрт суралцах оюутны хяналтын тоог тогтоох аргачлал

1. Тэнхимийн хөтөлбөрийн дэд хороо (тэнхимийн бүтэцгүй бол бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн дэд хороо) бакалаврын мэргэжлийн хөтөлбөрт суралцах оюутны хяналтын тоог тогтоохдоо энэ аргачлалыг баримтална.
2. Хяналтын тоог (тухайн хөтөлбөрт суралцах оюутны тоо) тэнхим/нэгжийн А цагийн ноогдол, анги танхим, лабораторийн багтаамж хүрэлцээ, оюутны тандалт судалгааны дүн дээр үндэслэн тогтооно.
  - 2.1. Тэнхим/нэгжийн багш нарын А цагийн ноогдолд үндэслэн санал болгож буй оюутны хяналтын тоог бүлгээр илэрхийлэн гаргах бөгөөд тухайн хөтөлбөрөөр суралцах нэг бүлгийн оюутны тоо 25-аас доошгүй байна.
  - 2.2. Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тусгай тоноглогдсон лаборатори, өрөөний ачаалалд үндэслэн тэнхимийн лабораторийн хүчин чадлыг бүлгээр илэрхийлэн тогтооно. Лекц, семинарын анги танхимын ачааллыг МУИС-ийн хэмжээнд нэгдсэн журмаар тооцно.
  - 2.3. Оюутны тандалтын нийт дүнг тухайн хөтөлбөрийн нэгдүгээр саналын нийт тоон дээр хоёрдугаар саналын тооны хагасыг нэмж бүлэгт байх оюутны тоонд хуваасны бүхэл утгаар тодорхойлно.
3. Хөтөлбөрийн хяналтын тоо нь бүлгийн тооны санал (2.1 ба 4-р зүйл), лабораторийн хүчин чадал (2.2 ба 5-р зүйл), оюутны тандалтын дүнд (2.3 ба 6-р зүйл) үндэслэн тооцоолсон дүнгүүдийн хамгийн бага утга байна.
4. Бүлгийн тооны саналыг тогтоох дараалал
  - 4.1. Тэнхим/нэгжийн хөтөлбөрийн дэд хороо багш нарын А цагийн багтаамж (ТЦБ), нийт хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд үүсэх А цагийн ачаалал (ТЦА) зэргийг нягтлан оюутны хяналтын тоог хөтөлбөр бүрээр бүлгээр илэрхийлнэ.
  - 4.2. Тэнхимийн цагийн багтаамжийг тэнхимд харьяалалтай багш нарын (01 тушаалын) А цагийн ноогдлын нийлбэрээр тооцно. Тодорхой үндэслэлээр тэнхимийн цагийн ноогдлыг 20% хүртэл хувиар өөрчилж болно.
  - 4.3. Тэнхимийн багш нарын А цагийн ачааллыг хариуцаж буй ерөнхий суурийн хичээлийн тоо, хөтөлбөрийн тоо, мэргэжлийн хичээлийн тоонд үндэслэн дараах томъёогоор тооцно. Хэмжих нэгж нь багц цаг байна.

$$ТЦА = МХХ + ЕС + МД$$

Үүнд:

*МХХ – Мэргэжлийн хичээлийн цагийн ачаалал (хуучин хөтөлбөрийн хувьд)*

2014 оноос өмнө батлагдсан хөтөлбөр бүрээс үүсэх ачааллыг тухайн тэнхимийн багш нар заах мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлийн нийт багц цагийг олох бөгөөд тэнхимийн нийт ачаалал нь бүх хөтөлбөрөөс үүсэх ачааллын нийлбэр байна.

*ЕС – Ерөнхий суурийн болон бусад хөтөлбөрийн хичээлийн цагийн ачаалал*

Өмнө хэрэгжиж буй хөтөлбөрийн сонгон суралцах хичээл, бусад тэнхим/сургуульд заах хичээлийг оруулна. Энд лекц, семинар, лабораторийн бүлгээр хичээллэх цагийг нарийвчлан тооцно.

*МД – Магистр, докторын сургалтаас үүсэх ачаалал*

Магистр докторын сургалтаас үүсэх ачааллыг профессор, дэд профессорын зэрэглэлд ажиллаж байгаа багш нар “МУИС-ийн Багшийн орон тоо, ажлын үнэлгээний журам”-ын 3-р бүлгийн 13 заалтыг үндэслэн 3-аас доошгүй багц цагийн хичээл заана

*МД = профессор, дэд профессорын зэрэглэлийн багшийн тоо \* 3Бц*

томьёогоор тогтооно.

4.4. Шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд үүсэх А цагийн ачаалал (МХШ) нь 2014-2015 оны хичээлийн жилээс тухайн тэнхимийн хариуцан хэрэгжүүлэх шинэ хөтөлбөрүүдийн мэргэжлийн хичээлийн нийт багц цагийн хэмжээ юм. Тухайлбал, Шинжлэх ухааны сургуулийн хувьд мэргэжлийн хичээлийн нийт багц цаг 60 Бц байна.

4.5. **Бүлгийн тоог тодорхойлох:** 2014-2015 оны хичээлийн жилд шинэ хөтөлбөрүүдээр сургах боломжтой бүлгийн тоог тэнхимийн цагийн багтаамж болон тэнхимийн цагийн ачааллын ялгаврыг шинэ хөтөлбөрөөс үүсэх цагийн ачаалалд харьцуулж олно:

$$\text{Бүлгийн тоо} = \frac{\text{ТЦБ} - \text{ТЦА}}{\text{МХШ}} \times 2.$$

4.6. **Хөтөлбөр бүрээр хичээллэх бүлгийн тооны саналыг тогтоох:** Тэнхим бүлгийн тоонд багтаан хөтөлбөр тус бүрээр хэдэн бүлэг хариуцах саналаа гаргана.

4.7. **Тэнхимийн хяналтын бүлгийн тоог тооцсон жишээ**

ШУС-ын А тэнхим 2 профессор, 4 дэд профессор, 5 ахлах багш, 6 багштай, 2 хөтөлбөр хариуцдаг бөгөөд шинээр 4 хөтөлбөр санал болгож байгаа гэж саная. А тэнхимийн цагийн багтаамж болон ачааллын талаарх мэдээлэл болон хэдэн бүлэг оюутанд үйлчлэх боломжтойг тооцоолсныг хүснэгтэд үзүүлэв.

Үзүүлэлт	Тооцоолсон үр дүн	Тайлбар
ТЦБ	296.4	$12 \times 2 + 13 \times 4 + 15 \times 5 + 16 \times 6 = 247$ Үүний 20% нь 49.4. Нийлбэр 296.4
МХХ	72	3 ба 4-р курст ихэвчлэн мэргэшүүлэх хичээл орно гэж үзээд хөтөлбөр бүр 36 Бц учир $2 \times 36$
ЕС	21	Нийт 7 лекцийн бүлэгт хичээл ордог гэе.
МД	18	$(2+4) \times 3$
ТЦА	111	$111 = 72 + 21 + 18$
МХШ	60	
Бүлгийн тоо	6	$(296.4 - 111) \times 2 / 60 = 6$ . Ө.х. 6 бүлэг оюутанд үйлчлэх боломжтой.
Хөтөлбөр бүрийн саналыг тэнхим 9 бүлэгт багтаан тогтооно.		1-р хөтөлбөр- 2 бүлэг 2-р хөтөлбөр- 1 бүлэг 3-р хөтөлбөр- 1 бүлэг 4-р хөтөлбөр- 2 бүлэг гэх мэт

5. Анги танхим, лабораторийн хүчин чадлыг дараах аргачлалаар тооцно. Лекц, семинарын анги танхимын ачааллыг МУИС-ийн хэмжээнд нэгдсэн журмаар тооцно. Лаборатори болон зөвхөн мэргэжлийн хичээлд зориулан тоноглогдсон, олон мэргэжлийн хичээл ордог эсвэл олон хөтөлбөрт үйлчилдэг өрөөний ачаалалд үндэслэн тэнхимийн лабораторийн хүчин чадлыг тогтооно.

5.1. Нэг улиралд нэг лабораторийн хүчин чадлыг 8-10 бүлэг гэж үзнэ.

5.2. 2015-2016 оны хичээлийн жилд 3, 4-р ангид орох нийт бүлгийн тоог өрөө тус бүрээр тооцоолно.

5.3. Тухайн өрөөний хувьд 20-өөс 5.2-т тооцоолсон бүлгийн тоог хасахад шинэ хөтөлбөрүүдэд үйлчлэх хүчин чадал гарна.


5.4. Өрөөний хүчин чадалд үндэслэн хөтөлбөр бүрээр санал болгох бүлгийн тоог тогтооно.

6. Оюутны тандалтын дүнд үндэслэн бүлгийн тоог дараах маягаар тогтооно.


6.1. Оюутны тандалтын нийт дүнг тухайн хөтөлбөрийн нэгдүгээр саналын нийт тоон дээр

хоёрдугаар саналын тооны хагасыг нэмж бүлэгт байх оюутны тоонд хуваасны бүхэл утгаар тодорхойлно.

- 6.2. Оюутны тандалтын дүн 15-аас цөөн байх тохиолдолд хөтөлбөрийн хяналтын тоог 15 гэж тогтооно.







МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
.....СУРГУУЛЬ  
СУРГАЛТЫН АЛБА

210646 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Бага тойруу 47. Факс: / Утас: 7730-7730

Хавсралт 2



МЭРГЭЖЛИЙН ХӨТӨЛБӨР СОНГОЛТ  
ХОЙШЛУУЛАХ ХҮСЭЛТИЙН МАЯГТ

1	Оюутны овог, нэр	
2	Оюутны дугаар	
3	Регистрийн дугаар	Хүйс .....
4	Мэргэжил сонголтоо хойшлуулах болсон шалтгаан	
5	Хүсэлт	Миний бие ..... сарын ..... -р сард МУИС-ийн ..... ..-ны сургуульд элссэн бөгөөд энэ удаад өөрийн хүсэлтээр мэргэжил сонголтоо хойшлуулахыг хүсэж байна. Энэ хүсэлтийг гаргаснаар би мэргэжил сонголтоо дараагийн жилийн элсэгчидтэй хамт хийнэ гэдгээ ойлгосон болно.
6	Хүсэлт гаргасан оюутны гарын үсэг	
7	Хүсэлт гаргасан огноо	
8	Хүлээж авсан сургалтын албаны мэргэжилтэн	
9	Хүлээж авсан огноо	


**Оюутан та, дараах АНХААРУУЛГЫГ үншиж, танилцана уу.**

Оюутан та, мэргэжил сонголтоо хойшлуулах хүсэлт гаргасан тохиолдолд дараагийн хичээлийн жилийн элсэгчидтэй хамт оноогоор жагсан, мэргэжил сонголтод орох болно. Энэ үед таны төгсөх хугацаа хойшилно гэдгийг анхаарна уу.

Мөн оюутан та, тухайн мэргэжлээ сонгож чадаагүй бол, тухайн мэргэжлийг хавсарга мэргэжил байдлаар эзэмших боломжтой юм.



Тэнхимийн дэд хорооны бөглөх маягт №1 (албан хэрэгцээнд)



**Хөтөлбөрийн хяналтын тооны санал**

(Тэнхим шинээр хэрэгжүүлэх хөтөлбөр бүрээр бөглөнө.)


	Үзүүлэлт		Тайлбар
	Тэнхимийн нэр		
	Хариуцах хөтөлбөрийн нэр		
	Тэнхимийн цагийн багтаамж (ТЦБ)		4.2 заалт
	Цагийн ачаалал ТЦА (МХХ+ЕС+МД)		4.3 заалт
	<i>МХХ</i>		
	<i>ЕС</i>		
	<i>МД</i>		
	МХШ (энэ хөтөлбөрийн)		4.4 заалт
	<b>Тэнхимээс санал болгох бүлгийн тоо</b>		4.5 заалт
	<b>Лабораторийн хүчин чадал (бүлгээр)</b>		5 заалт
	<i>Өроо 1</i>		
	<i>Өроо 2</i>		
	Оюутны тандалт (оюутны тоо)		6.1 заалт
	Нэгдүгээр саналын тоо		
	Хоёрдугаар саналын тоо		
	Нэг бүлэгт байх оюутны тоо (25-аас доошгүй)		2.1 заалт
0	<b>Оюутны тандалт (бүлгээр)</b>		6.1 заалт
1	Хяналтын бүлгийн тооны санал ()		3 заалт

Тэнхимийн эрхлэгч ...../ /

Огноо

Хүлээн авсан...../ /

Тэнхимийн дэд хорооны бөглөх маягт №2 (албан хэрэгцээнд)



Тэнхимийн мэргэжлийн хөтөлбөрүүдийн хяналтын тооны саналын нэгтгэл

	Үзүүлэлт	
	Тэнхимийн нэр	
	Хариуцах хөтөлбөрийн тоо	
	Тэнхимийн цагийн багтаамж (Бц-аар)	
	Тэнхимийн цагийн ачаалал ТЦА (МХХ+ЕС+МД)	
	МХХ	
	ЕС	
	МД	
	МХШ (нийт)	
	<b>Бүлгийн тоо</b>	
	<b>Бүлгийн тооны санал</b>	
	Хөтөлбөр 1	
	Хөтөлбөр 2	
	<b>Хяналтын тооны санал (Оюутны тоогоор)</b>	
	Хөтөлбөр 1	
	Хөтөлбөр 2	

Тэнхимийн эрхлэгч ...../ /

Огноо

Хүлээн авсан...../ /